

## **“КОВИД-19”-ИЙН ДЭГДЭЛТЭЭС ХОЙШИХ БНХАУ-ЫН ГАДААД БОДЛОГО, ӨӨРЧЛӨЛТ, ЧИГ ХАНДЛАГА**

Б.Анхбаяр

*ШУА-ийн Олон улсын харилцааны хүрээлэнгийн  
Хятад судлалын салбарын эрдэм шинжилгээний ажилтан,  
олон улсын харилцааны магистр*

**Товч агуулга:** БНХАУ 2019 оноос олон улсын харилцаанд гарч буй асуудлыг “Зуунд тохиогоогүй их өөрчлөлт, боломж” хэмээн томъёолох болсон бөгөөд 2020 онд “Ковид-19”-тэй холбоотойгоор дээрх зууны өөрчлөлт бодитоор үүсч БНХАУ-ын улс төр, аюулгүй байдлын орчинд томоохон өөрчлөлтийг авчрав. “Ковид-19” гарснаас хойших гадаад орчны өөрчлөлтөд БНХАУ олон улсад нэр хүндээ хамгаалах, байр сууриа бэхжүүлэх үйл ажиллагааг идэвхтэй явуулж байгаа ба үүнээс Бээжингийн гадаад бодлогын чиглэл, хандлагын өөрчлөлтийг ажиглаж болохоор байна. Энэхүү өгүүлэлд “Ковид-19” цар тахал гарсны дараах БНХАУ-ын гадаад бодлогын өөрчлөлт чиг хандлагыг өгүүлэх болно.

**Түлхүүр үг:** “Ковид-19”-ийн үзүүлсэн нөлөө өөрчлөлт, БНХАУ-ын гадаад бодлогын өөрчлөлт, БНХАУ-ын хөрш орнуудын бодлого

### **1. “Ковид-19”-ийн олон улсын харилцаанд үзүүлсэн өөрчлөлт нөлөө**

“Ковид-19” цар тахал улс гүрнүүдийн харилцаанд бугшиж байсан бүтцийн шинжтэй асуудал, зөрчлүүдийг ил болгов. Юун түрүүн “Ковид-19” улс орнуудын бүх талын чадамжийг сорьж байна. Дэлхийн улс орнууд “Ковид-19”-тэй тэмцэхэд улс төрийн тогтолцоо, засаглалын чадамж, эрх баригч хүчин, удирдагчийн чадвар, соёл шашин шүтлэг сэтгэлгээний ялгаа зэрэг олон хүчин зүйлээс шалтгаалж цар тахлын нөлөө харилцан адилгүй байгаа юм. Улмаар голлох гүрнүүдийн хүчин чадалд өөрчлөлт оруулж байна. “Ковид-19”-ийн нөлөөгөөр эдийн засаг нь хүнд цохилтонд өртөөд байгаа Баруун Европын орнууд, Япон, АНУ-тай харьцуулахад БНХАУ-ын эдийн засаг цар тахлын дараа хурдан сэргэж голлох эдийн засагтай орнуудаас ганцаараа эерэг үзүүлэлттэй байгаа нь их гүрнүүдийн аюулгүй байдлын болгоомж, эрх ашиг, ашиг сонирхлын өрсөлдөөн зөрчлийг нэмэгдүүлэв. Үүнээс гадна “Ковид-19” улс орнуудын дотоодын улс төрийн зөрчлийг хурцатгаж байгаагаас их гүрнүүдийн дотоод, гадаад бодлогод өөрчлөлт орох болов. Их

гүрний удирдагчид эрх мэдлээ хадгалах, дотоодынхоо эв нэгдлийг хадгалах зорилгоор дотоод асуудлыг гадаад орчинд чиглүүлж анхаарлыг сарниулах бодлого хэрэгжүүлж байна. 2020 оны АНУ, БНХАУ-ын харилцааны өөрчлөлт; БНХАУ, Энэтхэгийн газар нутгийн маргааны хурцадмал байдал зэргээс харж болох юм.

Цар тахал олон улсын харилцааны чиг хандлага “тоглоомын дүрэм”-ийг тодорхойлдог даяаршил, технологи, үйлдвэрлэлийн гинжин холбооны шилжилт өөрчлөлтийг хурдасгав. Даяаршлыг чиглүүлэх их гүрний манлайллын орон зай дутагдаж байх үед “Ковид-19” дэлхий даяар дэгдсэн нь даяаршлын давалгааг зогсоож сөрөг талыг нь улам тодруулснаар даяаршлын цаашдын чиг хандлагыг тодорхойгүй болгов. Цар тахлын өмнө үндэстэн дамнасан корпорациудын үйл ажиллагаа нь эдийн засгийн ашиг олох сонирхол дээр тулгуурладаг байсан болохоос улс төр аюулгүй байдлын санаа зорилго гол нөлөө үзүүлдэггүй байв. Харин “Ковид-19”-ийн дараа аюулгүй байдлын хэм хэмжээ ойлголт сэтгэлгээнд өөрчлөлт орж байна. Цар тахлаас хойш дэлхий даяар техник технологийн хэрэглээ хамаарал нэмэгдэж, их гүрнүүдийн дунд шинжлэх ухаан технологийн салбар дахь манлайллын өрсөлдөөнийг хурцатгаж байна.

## **2. БНХАУ-ын гадаад харилцаанд “Ковид-19”-ийн үзүүлсэн эерэг сөрөг тал**

БНХАУ “Ковид-19”-ийн халдварт анх өртсөн ч цар тахлыг харьцангуй амжилттай даван туулж байгаа нь БНХАУ-ын гадаад харилцаанд эерэг сөрөг нөлөөг үзүүлж байна. Үүнийг товч дурдвал:

Эерэг тал 1. БНХАУ засаглал тогтолцооны чадамжийн сурталчилгаа болов. “Ковид-19” анх БНХАУ-д гарч орон даяар хатуу хяналт хорио цээрийг тогтоож байхад барууны орнууд Бээжингийн засаглал, ХКН-ын том сорилт болж байна хэмээн бичиж байсан бол 3 дугаар сараас нөхцөл байдал эсрэгээрээ эргэж цар тахал нь БНХАУ-ыг дотоод, гадаад ертөнцөд өөрийн улс төрийн тогтолцоогоо сурталчлах, хүчин чадлаа харуулах боломж болон хувирав.

Эерэг тал 2. АНУ-ыг эдийн засгаар гүйцэх цаг хугацааг ойртуулав. “Ковид-19”-ийн өмнө БНХАУ-ын ДНБ-ний хэмжээ АНУ-ын ДНБ-ний 2/3-ийг эзэлж байсан бол 2020 оны төгсгөлд 3/4-ийг эзлэхээр хэмжээнд хүрэхээр байна. БНХАУ-ын ДНБ-ний хэмжээ АНУ-ыг гүйцэх цаг хугацааг богиносгож 2028 онд гүйцэж түрүүлэхээр байна. БНХАУ-ын эдийн засгийн эерэг үзүүлэлт нь цар тахлын дараах олон улсын харилцаанд Бээжингийн эрх ашгаа хамгаалсан улс төрийн чиг хандлагатай гадаад бодлогын гол “ар тал” болох юм.

Эерэг тал 3. БНХАУ-тай дайсагнасан бодлого үйл ажиллагаа явуулдаг Д.Трамп сонгуульд ялагдав. БНХАУ өнгөрсөн 3 жилийн турш Д.Трампын засаг захиргааг “аргадах” олон төрлийн бодлого арга хэмжээ авч хэрэгжүүлсэн ч Бээжин, Вашингтоны харилцаа жил ирэх тусам дордож улмаар “Ковид-19”-ийн дэгдэлтийн дараа бүх талыг хамарсан зөрчил болон хувирч БНХАУ-ын тэвчээрийг бараад байв. БНХАУ-ын “аз болоход” Д.Трамп “Ковид-19”-ийн нөлөөгөөр нэр

хүнд нь унаж ерөнхийлөгчийн сонгуульд ялагдав. Д.Трампын оронд бодлого үйл ажиллагааг нь таамаглаж болохоор Ж.Байден АНУ-ын ерөнхийлөгчөөр сонгогдсон нь БНХАУ-ын гадаад харилцаанд “амьсгаа авах” боломж өгөв.

Сөрөг тал 1. АНУ-тай харилцах харилцаа эргэлт буцалтгүй сөргөлдсөн хэлбэрт шилжив. БНХАУ байгуулагдсан 1949 оноос 1970-аад оны эхэн үе хүртэл Бээжин Вашингтон дайсагнасан харилцаатай байсан бол 1979 оноос тухайн цаг үеийн шаардлагаар дипломат харилцаа тогтоож орчин цагийн хамтын ажиллагааны циклд шилжсэн байдаг. Сүүлийн жилүүдэд судлаачид БНХАУ, АНУ-ын харилцааг дараагийн зөрчилт циклд шилжих нь цаг хугацааны асуудал хэмээн дүгнэн сануулж байсан. 2020 оны “Ковид-19”-ийн дэгдэлт нь БНХАУ, АНУ-ын зөрчлийн үйл явцыг бүх талаар хурдасгаж Бээжин, Вашингтоны харилцааг зөрчлийн шинэ циклд шилжүүлэв. Судлаачид БНХАУ, АНУ-ын харилцаа хамтын ажиллагаа зөвхөн тодорхой зорилготойгоор 30-40 жилийн циклтэйгээр өөрчлөгддөг реалист шинжтэй байгаа талаар онцолж байна.

Сөрөг тал 2. Аюулгүй байдал геостратегийн нөхцөл байдал хүндрэв. АНУ-тай харилцах харилцааны өөрчлөлтөөс шалтгаалж БНХАУ-ын бүс нутаг дахь эмзэг асуудлууд улам хурцдав. 2020 онд БНХАУ Зүүн тэнгисийн Дяо Юй (Сенкаку) арлаас Тайвань, Өмнөд хятадын тэнгис хүртлэх далай тэнгисийн бүсэд Япон, АНУ-тай, Төвөдийн өндөрлөгт Энэтхэгтэй газар нутгийн асуудлаар зөрчилдөв. Вашингтоны зүгээс Бээжинтэй зөрчилдөгч талуудыг нэгтгэж өөрийн санаачилсан “Энэтхэг, Номхон далайн стратеги”-т оролцуулахыг зорьж байгаа нь БНХАУ-ын цэрэг улс төр аюулгүй байдалд шууд заналхийлэл учруулж байна.

Сөрөг тал 3. Даяаршлын давалгаа татарч олон улсын худалдаа үйлдвэрлэлийн сэтгэлгээ өөрчлөгдөв. “Ковид-19”-ийн үед зайлшгүй шаардлагатай бүтээгдэхүүн, материал хэрэгслийн хамааралтай байдал үүссэн нь улс орнуудын аюулгүй байдлын зовнилыг нэмэгдүүлж бусад орноос ялангуяа БНХАУ-аас хараат байдалд байгааг мэдрүүлэв. Барууны орнууд зайлшгүй шаардлагатай бүтээгдэхүүнийг дотооддоо үйлдвэрлэх эсвэл үзэл суртал тогтолцоо адил холбоотон орнуудад шилжүүлэх талаар ярилцаж холбогдох бодлого арга хэмжээг авч эхлээд байгаа нь БНХАУ-ын үйлдвэрлэгч их гүрний байр суурийг ганхуулах эрсдэлтэй юм.

“Ковид-19”-ийн БНХАУ-ын гадаад бодлогод үзүүлсэн эерэг тал нь цаг үеийн шинжтэй давуу байдал авчирч байгаа бол цар тахлын үзүүлж буй сөрөг тал нь бүтцийн зөрчлийн шинжтэй буюу БНХАУ-ын гадаад бодлого хэзээ нэгэн цагт нүүр тулах асуудлууд байгаа юм.

### **3. БНХАУ-ын гадаад бодлогын өөрчлөлт, чиглэл хандлага**

БНХАУ Ши Жиньпиний “Хятад үндэстний их сэргэн мандалт” хэмээх реалист шинжтэй дотоод улс төрийн зорилтыг биелүүлэхийн тулд гадаад бодлогодоо “хүн төрөлхтний нийтлэг хувь заяаны нэгдэл” гэсэн конструктивизм онолын үзэл санааг дэвшүүлэн хэрэгжүүлэх болсон. Даяаршсан ертөнцөд “Ковид-19” хэмээх

цар тахал гарснаар хүн төрөлхтөн урьд өмнө нь байгаагүй улс төр, эрүүл мэнд, аюулгүй байдал, нийгэм эдийн засгийн нийтлэг сорилттой зэрэг тулгарч сэтгэлгээ үзэл санаа, технологийн томоохон өөрчлөлтөд орж байна. Энэхүү өөрчлөлт дунд БНХАУ-ын “хүн төрөлхтний нийтлэг хувь заяаны нэгдэл” гэх гадаад бодлогын үзэл баримтлал нь олон улсын харилцаанд Бээжингийн байр суурь нэр нөлөөг нэмэгдүүлэх чиглэл болж байгаа юм.

Цар тахал гарснаас хойш БНХАУ олон улсад хариуцлагатай их гүрний дүр төрхийг бүрдүүлж “Ковид-19”-ийн тархалтаас үүдэлтэй хариуцлага шүүмжлэлээс нэр хүндээ хамгаалах бодлого арга хэмжээг авав. 2020 оны 6 дугаар сард “Ковид-19”-ийн эсрэг явуулсан үйл ажиллагааны “цагаан ном”-ыг гаргаж, БНХАУ цар тахлын анхны хохирогч болсны дараа “Ковид-19”-тэй хэрхэн тэмцэж даван туулсан болон олон улстай хэрхэн хамтарч ажилласан тухайгаа танилцуулсан. “Ковид-19”-ийн халдвар гарнаас хойш БНХАУ дэлхийн 150 гаруй улс оронд эм, эмнэлэгийн багаж хэрэгслийн тусламж илгээж, ДЭМБ, НҮБ-ын хүмүүнлэгийн санд тус бүр 50 сая доллар хандивлаж, хөгжиж буй 77 улсын өрийн төлөлтийг түр зогсоох болсноо зарласан. Эдгээр нь “Ковид-19”-ийн дараах олон улсын харилцаанд БНХАУ-ын үүрэг ролийг нэмэгдүүлэх, “хүн төрөлхтний нийтлэг хувь заяа”-ны үзэл санааг дэлхий дахинд сурталчлах зорилгыг агуулж байгаагаас гадна Вашингтоны Бээжинг буруутгаж байгаа дайралтын эсрэг хийж буй “зөөлөн хүч”-ний хариу арга хэмжээ байна. “Ковид-19” хэмээх гэнэтийн цар тахал олон улсын харилцаанд бугшиж байсан их гүрнүүдийн хоорондох бүтцийн зөрчлийг өдөөн хурдасгаснаар БНХАУ-ын бусад орнуудтай харилцах улс төрийн зөрчилт харилцаанд баримтлах хариу арга хэмжээний агуулга хэлбэр ихээхэн өөрчлөгдөв.

**3.1 БНХАУ-ын гадаад бодлогод гарсан агуулгын өөрчлөлт:** 2020 оноос өмнө БНХАУ, АНУ-ын тогтолцоо үзэл суртлын ялгаатай байдал нь талуудын ашиг сонирхлын зөрчлийг өдөөдөг байсан бол “Ковид-19”-ийн тархалтын дараагаас үндэсний эрх ашигт шууд чиглэсэн зөрчил болж өөрчлөгдөв. Хэдийгээр БНХАУ-ын зүгээс АНУ-тай шууд зөрчилдөхөөс зайлсхийж ирсэн ч “Ковид-19” гарснаас хойш болсон үйл явдлууд Бээжинг Вашингтонтой сөргөлдөхөөс аргагүй байдалд хүргэв. 2020 оны 5 дугаар сарын 20-ны өдөр АНУ БНХАУ-тай харилцах стратегийн чиглэлийг<sup>1</sup> (United States Strategic Approach to the People’s Republic of China) гаргаж Бээжингийн байр суурь нөлөөний өргөжин тэлэлтийг хязгаарлах Вашингтоны бодлого арга хэмжээг танилцуулав. 2020 оны 7 дугаар сарын 21-ний өдөр АНУ Хьюстон хот дахь БНХАУ-ын Консулын газрыг Тагнуулын үйл ажиллагаа явуулсан гэх шалтгаанаар хаасан бол үүний хариуд БНХАУ Чэн Дү хот дахь АНУ-ын Консулын газрыг хаав. 7 дугаар сарын 23-ны өдөр АНУ-ын төрийн нарийн бичгийн дарга М.Помпео хэлэхдээ, “1970-аад онд Вашингтон Бээжинтэй харилцаагаа сайжруулсан нь хүйтэн дайны үеийн АНУ-ын эрх ашигт нийцэж

1 United States Strategic Approach to the People’s Republic of China <https://www.whitehouse.gov/wp-content/uploads/2020/05/U.S.-Strategic-Approach-to-The-Peoples-Republic-of-China-Report-5.20.20.pdf>

байснаас гадна БНХАУ-тай эдийн засгийн хамтын ажиллагааг хөгжүүлж ХКН-ын (хятадын коммунист нам) засаглалыг барууны орнуудын улс төрийн үзэл сурталд нийцсэн байдлаар өөрчлөх зорилготой байсан ч амжилтанд хүрсэнгүй”<sup>1</sup> гэж мэдэгдсэн нь олон улсад “шинэ хүйтэн дайн”-ы болгоомжлол төрүүлэв. 9 дүгээр сараас хоёр улс харилцан өөрийн улсад суугаа дипломат ажилтнуудын үйл ажиллагаанд хязгаарлалт тавих болсноо зарлав<sup>2</sup>. 2020 оны эцэс гэхэд АНУ-д байгаа бүх Күнзийн төвийг хаах болсноо зарлан, АНУ-д суралцах БНХАУ-ын оюутнуудад хязгаар тогтоож, улмаар ХКН-ын гишүүдэд АНУ зорчих визийн хориг тавив.

БНХАУ Хонконгт “үндэсний аюулгүй байдлын хууль” хэрэгжүүлж, ардчилсан хүчний парламентын 4 гишүүний эрхийг цуцалсны хариуд АНУ Хонконгийн эх газрын хятадаас ялгагдах худалдааны статусыг цуцалж Хонконгийн удирдлагууд болон БНХАУ-ын Ардын их хурлын байнгын хорооны 14 гишүүнд хориг арга хэмжээ авав. 2020 оны 8 дугаар сард АНУ-ын Эрүүл мэндийн сайд Алекс Азар (Alex Azar), 9 дүгээр сард Төрийн нарийн бичгийн даргын орлогч Кит Крач (Keith Krach) нь Тайваньд айлчилсан нь 1979 онд АНУ Тайваньтай дипломат харилцаагаа тасалснаас хойш Вашингтоноос Тайбэйд айлчилсан хамгийн өндөр албан тушаалтнууд болов. Үүний хариуд Бээжингийн зүгээс Хонконг Тайваний асуудалд БНХАУ-ын эрх ашгийг зөрчсөн гэж үзсэн АНУ-ын холбогдох улс төрч, зарим албаны хүмүүст хориг тавив. БНХАУ-ын хувьд Хонконг, Тайвань гэх “дотоод өвчин гадаад шарх”-ыг өөрийн хүсэл арга барилаар шийдвэрлэхэд АНУ тэргүүтэй барууны орнуудтай зайлшгүй зөрчилдсөөр байгаа нь яваандаа тогтолцоо үзэл суртлын зөрчил болж даамжрах эрсдэлтэй байна.

БНХАУ АНУ-аас бусад орнуудтай харилцахдаа харьцангуй реалист буюу бярдсан шинжтэй харилцаж байгаа бөгөөд харилцааны зөрчлийн агуулга хэм хэмжээ нь ашиг сонирхлын зөрчлөөс эрх ашгийн зөрчил болж гүнзгийрч өөрчлөгдөв. Бээжингийн зүгээс бусад улс орнуудыг БНХАУ, АНУ-ын зөрчилд аль талын байр суурийг баримтлаж байгаагаас нь харгалзаж худалдаа эдийн засгийн хамтын ажиллагааг хөгжүүлэх эсэхээ шийдэж байна. Хэрэв тухайн улс АНУ-ын талыг баримтлаж байвал урьд өмнө нь гаргаж байгаагүй зөрчлийн хурц хэлбэрийг хэрэглэж “шийтгэх” болов. 2020 оны 4 дүгээр сард Австралийн Ерөнхий Сайд Скот Морисон АНУ-ын ерөнхийлөгч Д.Трамптай утсаар ярих үедээ “Ковид-19”-ийн гарал үүслийн талаар олон улсын шалгалт явуулах талаар хэлсний дараа БНХАУ иргэдээ Австрали улсад аялахгүй очиж суралцахгүй байх талаар мэдэгдэл гаргав. БНХАУ 5 дугаар сарын дунд үеэс Австралиас импортолдог үхрийн маханд хэсэгчлэн хориг тавьж, арвайд 80%-ийн гаалийн татвар ноогдуулж, дарс,

1 М.Помпео-гийн “Шинэ төмөр хөшигний илтгэл” дэлхий дахин Хятадын ард иргэдэд хандаж “ХКН-ыг өөрчлөх”-ийг уриалав. 蓬佩奥发表“新铁幕演讲”呼吁世界和中国人“改变中国共产党” [https://www.bbc.com/zhongwen/simp/world-53519761?fbclid=IwAR397iiEAG9ztcEpF-1Nf8GromcbBTyvAa0Z3chcUgUbQnaKrl\\_KjulaHFU](https://www.bbc.com/zhongwen/simp/world-53519761?fbclid=IwAR397iiEAG9ztcEpF-1Nf8GromcbBTyvAa0Z3chcUgUbQnaKrl_KjulaHFU)

2 БНХАУ, АНУ-ын харилцаа: АНУ, БНХАУ-ын дипломатуудад тавьсан хоригийн хариуд БНХАУ хятадад суугаа АНУ-ын дипломатуудын үйл ажиллагаанд хязгаарлалт тавив 中美关系：中国限制美国驻华外交人员活动 回击美方举措 <https://www.bbc.com/zhongwen/simp/world-54008820>

чихэр, модон эдлэлд импортын хориг тавив. Улмаар 12 дугаар сараас БНХАУ Австралиас нүүрс импортлохоо зогсоох шийдвэр гаргасан. Одоогоор Австралийн нийт экспортын 38.09%-ийг БНХАУ эзэлж байдаг бол Австралийн эдийн засагт экспортын эзлэх хувь ойролцоогоор ДНБ-ний 20% байна. БНХАУ-ын Австралид авч буй худалдаа эдийн засгийн хатуу арга хэмжээ нь бусад улсуудад Бээжинтэй улс төрийн зөрүүтэй байр суурь баримталснаар ямархуу байдалд хүрэхийг харуулсан сануулга болж байна.

**3.2 БНХАУ-ын гадаад бодлогод гарсан хэлбэрийн өөрчлөлт:** Урьд өмнө нь харьцангуй аядуу тойруу байдлаар зөрүүтэй эсэргүүцсэн байр сууриа илэрхийлдэг байсан БНХАУ-ын гадаад харилцааны үг хэллэг “Ковид-19”-ийн тархалтын үеэр илт өөрчлөгдөж хар цагааны зааг хязгаарыг гарган хэлдэг болов. БНХАУ-ын дипломатчид барууны ертөнцөд өргөн хэрэглэгддэг твиттерт идэвхтэй үзэл бодлоо илэрхийлж Бээжингийн байр суурийг хамгаалах болов. Олон улсад “Ковид-19” хурдтай тархаж АНУ өвчлөгчдийн тоогоор дэлхийд тэргүүлэх болсон үеэс АНУ-ын зүгээс “БНХАУ цар тахлын үүсэл тархалтад хариуцлага хүлээх ёстой, мэдээллийг нуун дарагдуулж дэлхий нийтэд худал мэдээлэл тараасан” хэмээн шүүмжилсний хариуд БНХАУ-ын дипломатууд АНУ-ыг хүчтэй эсэргүүцсэн хатуу мэдэгдлүүдийг хийсэн. Үүнээс хойш БНХАУ-ын дипломатуудын барууны орнуудын эсрэг хийх хатуу мэдэгдлүүдийг “дайчин чононы дипломат харилцаа” (Wolf Warrior Diplomacy) гэж олон улсад нэрлэх болов.

БНХАУ-ын гадаад хэргийн сайд Ван И-гийн 9 дүгээр сарын 28-ны өдөр болсон олон улсын “Лантинг форум”-ын үеэр хэлсэн үгэндээ олон улсын хамтын ажиллагааг чухалчилж нэр дурдахгүйгээр АНУ-ын бодлого үйл ажиллагааг шүүмжилж төгсгөлд нь бусад улс орнуудыг “сонголтоо зөв хийх хэрэгтэй”<sup>1</sup> гэж мэдэгдэв. Мөн Ван И 12 дугаар сарын 11-ний өдөр “олон улсын нөхцөл байдал ба БНХАУ-ын гадаад харилцаа” хуралд хэлсэн үгэндээ “2020 он хүн төрөлхтний түүхэнд томоохон өөрчлөлт эргэлтийг авчирсан чухал жил байлаа. ...дэлхий ертөнц өнгөрсөн үе рүүгээ буцах боломжгүй, хүмүүс ирээдүйгээ эрэлхийлж байна. Улс орнууд “эвлэлдэн нэгдэх үү, хуваагдах уу”, “нээлтэй байх уу эсвэл хаагдмал байх уу”, “хамтран ажиллах уу эсвэл сөргөлдөх үү” гэсэн чухал сонголтуудтай тулгараад байна...”<sup>2</sup> гэв. Ерөнхийдөө БНХАУ 2020 онд “БНХАУ-ын авч хэрэгжүүлж буй бодлого үйл ажиллагаа нь зөв ёс суртахуунтай байгаа тиймээс бусад улсууд Бээжингийн байр суурийг дагах нь зөв сонголт байх болно” гэсэн утга агуулга бүхий үгсийг олон улсын хурал болон олон нийтийн цахим сүлжээнд илэрхийлсэн. Энэ нь урьд өмнөх Бээжингийн гадаад харилцааны уламжлалт үг хэллэгээс хэлбэр агуулгын хувьд илт өөр байгаа юм.

1 Хагарал хуваагдлаас сэргийлж хамтын ажиллагаагаа бэжүүлэх нь олон улсын хамтын нийгэмлэгийн цор ганц зөв зам 加强团结合作，防止对抗分裂，是国际社会唯一正确选择 [http://newyork.fmprc.gov.cn/web/ziliao\\_674904/zt\\_674979/dnzt\\_674981/qtzt/ltlt\\_675065/dsbjltlt/t1819523.shtml](http://newyork.fmprc.gov.cn/web/ziliao_674904/zt_674979/dnzt_674981/qtzt/ltlt_675065/dsbjltlt/t1819523.shtml)

2 Ван И 2020 оны олон улсын нөхцөл байдлын талаар яриw. 王毅谈2020年国际局势 [http://www1.fmprc.gov.cn/web/ziliao\\_674904/zt\\_674979/dnzt\\_674981/qtzt/kjgzbdffyq\\_699171/t1839404.shtml](http://www1.fmprc.gov.cn/web/ziliao_674904/zt_674979/dnzt_674981/qtzt/kjgzbdffyq_699171/t1839404.shtml)

**3.3 БНХАУ-ын гадаад бодлогын чиглэл:** БНХАУ-ын гадаад бодлого цаашдаа АНУ-тай харилцах харилцаа болон бусад улс орнуудтай харилцах харилцаа гэсэн ерөнхий хандлагатай болоод байна.

БНХАУ-ын АНУ-тай харилцах гадаад бодлогын чиглэл нь АНУ-ын ерөнхийлөгчийн байр суурь, бодлогын үйл ажиллагаанаас хамаарч тодорхойлогдож байна. АНУ-ын шинэ ерөнхийлөгч Ж.Байден БНХАУ-тай харилцахдаа харьцангуй таамаглаж болохоор бодлогын байр суурь баримтлаж Бээжинг шууд өдөөн хатгасан алхам (Тайваньтай “дотно” харилцах, Өмнөд хятадын тэнгист цэргийн сургуулалт хийх гм) хийхээс зайлсхийж, Вашингтоны холбоотны хүчийг ашиглаж, олон улсын харилцааны дүрмийн дагуу Бээжинг хязгаарлах алхам хийх төлөвтэй байна. Ж.Байденг ерөнхийлөгч болсны дараа Бээжин, Вашингтоны хурцадмал харилцаа тодорхой хэмжээнд зөөлөрч, зөрчилдөх хэв шинж агуулгын хувьд тодорхой хэмжээний өөрчлөлт гарахаар байна. Д.Трампын засаг захиргааны үед Вашингтоноос Бээжинд голчлон худалдаа эдийн засаг, улс төр үзэл суртал, цэрэг батлан хамгаалахын хүчтэй шахалтыг үзүүлж, хүний эрхийн асуудлыг тактикийн шинжтэй хэрэглэж байсан. Харин Ж.Байденгийн үед Бээжинд үзүүлэх цэрэг, улс төр үзэл суртал, худалдааны шахалтыг харьцангуй багасгаж, хүний эрхийн асуудлыг БНХАУ-д үзүүлэх үндсэн шахалтаа болгон Ази, Номхон далайн бүс нутагт Бээжингийн эсрэг олон улсын дуу хоолойг чиглүүлэхээр байна. БНХАУ-ын судлаачид Бээжин, Вашингтоны харилцааг Б.Обамагийн үеийн харилцааны түвшинд очно гэсэн найдлага тавихгүй байна. АНУ-ын шинэ засаг захиргаа Д.Трампын үед БНХАУ-ын эсрэг гаргасан худалдаа эдийн засгийн дийлэнх шийдвэрийг хэвээр үлдээж; Энэтхэг, Номхон далайн стратеги, АНУ, Энэтхэг, Япон, Австрали 4 улсын хамтын ажиллагааг үргэлжүүлэн Европ, Ази дахь АНУ-ын холбоотны харилцааг сэргээн бататгахаа мэдэгдээд байна.

Нөгөө талаар Ши Жиньпин засгийн эрхэнд гарснаас хойш БНХАУ гадаад харилцаандаа Ази, Европ, Африк, Америк тивийн улсуудыг багтаасан Бээжин төвтэй “Найзын хүрээ” хэмээх шинэ нэршлийг бий болгосон. Уг “Найзын хүрээ”-ний гол зангилаа нь БНХАУ-ын хөрш орнуудын болон хөгжиж байгаа орнуудын бодлогыг нэгтгэсэн олон талт хамтын ажиллагааны “Бүс ба зам” санаачилга юм. Цаашид цар тахлын дараах БНХАУ-ын гадаад бодлогод хөрш орнуудын бодлого, хөгжиж байгаа орнуудын бодлого улам бүр нэгдсэн шинж чанартай болж АНУ-тай хийх их гүрний өрсөлдөөнд тэднийг нэгдсэн байдлаар Бээжингийн талд байлгах зорилго чиглэлийг агуулж байна.

#### **4. БНХАУ-ын хөрш орнуудын бодлого, цаашдын төлөв**

Бээжин, Вашингтоны зөрчил сөргөлдөөн хурцадсанаас хойш БНХАУ хөрш орнуудынхаа хандлага, бодлогын өөрчлөлтөнд онцгой анхаарч байна. БНХАУ-ын хөрш орнуудын бодлогыг ерөнхийд нь Зүүн хойд Ази, Зүүн өмнөд Ази, Өмнөд Ази, Төв Ази, Баруун Ази хэмээн бүсчлэн хуваадаг юм. Цар тахал гарснаас хойш БНХАУ хөрш орнуудын байршил, хоорондын эрх ашиг, ашиг сонирхлын хамаарал, тогтолцооны онцлог, байгуулсан түншлэлийн харилцааны түвшинтэй нь уялдуулан илүү мэдрэмтгий, илүү зорилтот чиглэлтэй гадаад бодлого хэрэгжүүлэх болов.

“Ковид-19”-ийн тархалтын дараа БНХАУ-ын стратегийн ар тал болсон ОХУ, Төв Азийн бүс нутгийн орнуудтай стратегийн түншлэлийн харилцаагаа баталгаажуулан АНУ-ын бодлого үйл ажиллагааны эсрэг хамтарсан байр суурь баримталж, олон талт хамтын ажиллагаа бүс нутгийн асуудлуудад дуу хоолойгоо нэгтгэх чиглэлээр идэвхтэй ажиллаж байна. Сүүлийн жилүүдэд БНХАУ-ын Төв Ази ШХАБ-ын хүрээнд хийсэн гадаад үйл ажиллагаанд Монгол Улсыг хамруулах болсон нь анхаарал татаж байна. 2019 оны 6 дугаар сард ШХАБ-ын хүрээнд зохион байгуулагдсан Монгол, БНХАУ, ОХУ-ын гурван улсын тэргүүн нарын уулзалтаар Монгол Улсыг ШХАБ-д гишүүнээр элсэн орох талаар “нөхөрсөг шахалт” үзүүлсэн бол 2020 оны 9 дүгээр сард БНХАУ-ын гадаад хэргийн сайд Ван И ШХАБ-ын уулзалтад оролцоод нутаг буцах замдаа Монголд айлчилсан байдаг. БНХАУ-ын хувьд ОХУ болон Төв Азийн орнуудыг улс төр аюулгүй байдлын найдвартай ар тал, олон улсын тавцанд Бээжинг дэмжих гол хүч болгохыг зорьж байгаа бөгөөд ингэхдээ манай улсыг аажмаар тус бүс нутагт шахан оруулах санаа агуулж байхыг үгүйсгэхээргүй байна.

Зүүн хойд Азийн бүс нутаг нь БНХАУ-ын улс төр аюулгүй байдалд онцгой ач холбогдолтой төдийгүй эдийн засгийн хамтын ажиллагаа интеграци өргөжүүлэх боломжтой бүс нутаг юм. 2021 онд БНХАУ-ын удирдагч Ши Жиньпин Япон, Өмнөд Солонгост айлчлахаар төлөвлөөд байгаа, энэ үед гурван талын чөлөөт худалдааны хэлэлцээр түлхүү яригдаж урагшлах болно гэсэн хүлээлттэй байна. Урьд өмнө нь гурван улсын чөлөөт худалдааны хэлэлцээрийг идэвхтэй яригдах болгонд солонгосын хойгийн асуудал, гурван талын түүх, газар нутгийн маргаан хурцдаж улс төрийн нөлөө шалтгаанаар зогсонги мухардмал байдалтай болдог байсан, үүнийг АНУ-ын улс төрийн оролцоо нөлөө гэж БНХАУ-ын судлаачид харддаг юм. БНХАУ Солонгосын хойгийн аюулгүй байдлын асуудлыг өөрийн хяналтад байлгаж, Япон, Өмнөд Солонгостой эдийн засгийн хамтын ажиллагааг өргөжүүлэн бүс нутаг дахь АНУ-ын холбоотны харилцааг хөндийрүүлэх боломжийг эрэлхийлэх төлөвтэй байна.

БНХАУ Зүүн өмнөд Азийн орнуудтай улс төр эдийн засаг, аюулгүй байдлын гүнзгий холбоотой, зарим орнуудтай нь газар нутгийн маргаантай учраас

өрсөлдөгч АНУ-д тус бүс нутгийн санаачилгыг алдаж болохгүй. Тиймээс Зүүн өмнөд Азийн бүс нутаг нь “Ковид-19”-ийн дараах БНХАУ, АНУ-ын зөрчлийн “халуун цэг” болно. БНХАУ цар тахал гарснаас хойш бүс нутгийн орнуудыг аргадсан, анхааруулсан мэдэгдлийг удаа дараа хийж онцгой анхаарал хандуулж байна. БНХАУ өөрийн гаргаж авсан “Ковид-19”-ийн вакциныг хамгийн түрүүнд АСЕАН-ны орнуудад нийлүүлэхээ мэдэгдээд байгаа юм. БНХАУ Ази, Номхон далайн орнуудтай олон талт худалдаа, эдийн засгийн интеграцыг өргөжүүлэх, Зүүн өмнөд Азийн орнуудыг улс төр, эдийн засгаар татах зорилгоор 11 дүгээр сарын 15-ны өдөр бүс нутгийн эдийн засгийн иж бүрэн түншлэлд (RCEP, Regional Comprehensive Economic Partnership) гарын үсэг зурав<sup>1</sup>. АНУ, Энэтхэг ороогүй энэхүү түншлэл нь БНХАУ-ын хувьд бүс нутагт манлайлал давамгайл байдлаа бий болгох, геополитикийн орон зайгаа хамгаалж нөлөөллөө тэлэх, АСЕАН-ны орнуудын аюулгүй байдлын зовнил эргэлзээг бууруулж бүс нутаг дахь АНУ-ын оролцоог шахан гаргах геостратегийн ач холбогдолтой юм.

БНХАУ, Энэтхэгийн газар нутгийн маргаан 2020 оны 5-р сараас хойш Төвөдийн өндөрлөгт хурцдаж талууд хилийн дагуу их хэмжээний цэрэг байршуулаад байгаа ба хурцадмал байдал цаашид намжих төлөвгүй байна. Энэ онд АНУ-ын санаачилсан “Энэтхэг, Номхон далайн стратеги”-ийн хүрээнд АНУ, Энэтхэг, Австрали, Японы гадаад хэргийн сайд нар 10 дугаар сарын эхээр Токиод уулзаж, 11 дүгээр сард Энэтхэгийн далайд 4 улсын хамтарсан цэргийн сургуулилалт хийсэн нь бүс нутагт БНХАУ-ын эсрэг чиглэсэн эвсэл үүсэх хардлагыг нэмэгдүүлээд байна. БНХАУ АНУ-тай зөрчилдөж байгаа өнөө үед стратегийн өөр чиглэлд (Өмнөд Азийн бүс нутагт) бусад их гүрэнтэй зөрчилдөхгүй байхыг эрмэлзэж, гэхдээ Бээжингийн зүгээс Дели-д нөхцөл байдлыг буруугаар үнэлж болохгүйг сануулсаар байгаа юм. БНХАУ-ын хувьд газар нутгийн асуудалд буулт хийхгүй хатуу байр суурийг баримтлахын зэрэгцээ Энэтхэгийг АНУ-ын санаачилсан “Энэтхэг, Номхон далайн стратеги”-г оруулахгүйгээр хоёр талын харилцааг тогтвортой байлгах гэж хичээж байна.

Ийнхүү Бээжин, Вашингтоны сөргөлдсөн харилцаа БНХАУ-тай хөрш бүс нутгийн орнуудыг аль нэг талыг хүчээр сонгох тулгалтад оруулах болов. Ийм нөхцөлд ОХУ-ын судлаачид Бээжин, Вашингтоны зөрчилд аль нэг талыг барьсан байр суурь баримтлахгүй байхыг зөвлөж байна. Москвагийн Улсын судалгааны их сургуулийн олон улсын харилцааны мэргэжилтэн Дмитрий Суслов: “БНХАУ, АНУ-ын сөргөлдөөнөөс гаднах гуравдагч хүчин болохыг ОХУ хичээж хэрэгтэй, ОХУ цаашид Москва, Бээжин, Вашингтоны гурвалжингаас гаднах харилцааг үүсгэж Энэтхэг, Баруун Европ, Япон улсуудтай харилцаагаа сайжруулах шаардлагатай” гэв. ОХУ-ын Валдай клубын судалгааны захирал Фёдора Лукьянов (Fedor Lukyanov): “ОХУ-ын гадаад бодлого улам бүр хурцдаж байгаа БНХАУ, АНУ-ын сөргөлдөөнд оролцохоос зайлсхийх хэрэгтэй бөгөөд ОХУ цаашид Энэтхэг зэрэг Бээжин, Вашингтоны зөрчилд аль нэг талыг сонгохыг хүсэхгүй

<sup>1</sup> China signs huge Asia Pacific trade deal with 14 countries <https://edition.cnn.com/2020/11/16/economy/rcep-trade-agreement-intl-hnk/index.html>

байгаа улсуудтай харилцаагаа хөгжүүлэх шаардлагатай”<sup>1</sup> гэсэн байр суурь илэрхийлж байна. Үүнээс харахад ОХУ аль болох БНХАУ, АНУ-ын зөрчлөөс зайлсхийж бүх талаар аль нэг талыг дэмжихгүй байхыг зорих төлөвтэй байгаа нь харагдав. ОХУ нь БНХАУ, АНУ-ын зөрчлийн аль нэг талд орохгүйгээр гуравдагч хүчнүүдийн эгнээг Энэтхэг зэрэг бүс нутагтаа нөлөө бүхий орнуудтай хамтарч үүсгэвэл Бээжин, Вашингтонтой сонголттой харилцах орон зайг бий болгох магадлалтай гэж үзэж байна. Хэрэв гуравдагч хүчний улсуудын албан бус нэгдэл үүсвэл БНХАУ, АНУ-ын зөрчил талцлаас зайлсхийж буй улсуудын хорогдох гарц байж болох талтай юм.

## 5. Дүгнэлт

“Ковид-19”-ийн дэгдэлт БНХАУ, АНУ-ын зөрчлийн үйл явцыг бүх талаар хурдасгаж Бээжин, Вашингтоны харилцааг эргэлт буцалтгүйгээр зөрчлийн шинэ циклд шилжүүлэв. 2020 онд БНХАУ-ын гадаад харилцааны үг хэллэг илт хурц болж, илэрхийлэх хэлбэр агуулга нь өөрчлөгдөөд байгаа бөгөөд Бээжингийн зүгээс “Ковид-19”-ийн дараах олон улсын нөхцөл байдлын өөрчлөлтийг чиглүүлэх, байр сууриа нэмэгдүүлэхээр идэвхтэй ажиллаж байна.

БНХАУ бүс нутгийн стратегийн ач холбогдол бүхий орнуудтай улс төрийн харилцааг ойртуулж, эдийн засгийн хамтын ажиллагаагаа гүнзгийрүүлж бүс нутгаас АНУ-ын оролцоо нөлөөллийг шахан гаргах урьдчилсан алхамуудыг шат дараатай хэрэгжүүлж байна. Цаашид БНХАУ бүс нутгийн орнуудыг худалдаа эдийн засгаар татаж (шахалтад оруулж), Бээжингийн улс төрийн байр суурийг дэмжүүлэх бодлогыг цаашид улам түгээмэл хэрэглэхээр байна. Нөгөө талаар бүс нутгийн орнууд БНХАУ, АНУ-ын зөрчил дунд аль нэг талыг хүчээр сонгох эрсдлээс болгоомжилж тал сонгохгүй гуравдагч хүчнүүдийн эгнээг бүрдүүлэх тухай ярих болсон нь анхаарал татаж байна. Хэрэв ОХУ, Энэтхэг тэргүүтэй гуравдагч хүчний эгнээ бүрдсэн тохиолдолд БНХАУ, АНУ-ын зөрчил талцлаас зайлсхийх манай улсын гадаад бодлогын гарц байж болох юм.

---

1 БНХАУ, АНУ-ын сөргөлдөөн: ОХУ-ын судлаачид Москваг “Уламжлалт сэтгэлгээнээсээ салж” гуравдагч хүчин болохыг санал болгож байна. 中美对决：俄国智库建议莫斯科“超脱”成为第三力量 <https://www.bbc.com/zhongwen/simp/world-52809805>